



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 8/529

Улаанбаатар хот

“Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II”-ийн дүрэм, бүтэц, орон тоог батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 107 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II”-ийн дүрмийг нэгдүгээр, “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II”-ийн бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II”-ийн батлагдсан бүтэц, орон тоо, дүрмийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллахыг “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II”-ийн Ерөнхий захирал /А.Эрдэнэтуюя/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД

Т.МӨНХСАЙХАН

“ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ-II”-ИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II” (цаашид Төв гэх) нь улсын хэмжээнд эх, эмэгтэйчүүд, ураг-нярай, эд төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах, мэргэжлийн дүгнэлт гаргах лавлагаа төв мөн.

1.2. Төв нь нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх барих, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхдийн анагаах, хүүхдийн мэс заслын чиглэлээр лавлагаа тусlamж үзүүлэх, оношилгоо, эмчилгээний стандарт, заавар, арга зүйн зөвлөмж боловсруулах, эх, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхдийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн тархалт, нас баралтын тандалтын тогтолцоог бүрдүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага болно.

1.3. Төв нь байгууллагын стратеги төлөвлөгөөтэй байна.

1.4. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журам, тушаал шийдвэрийн дагуу явуулна.

1.5. Төв нь “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II” гэсэн хаягтай байна.

1.6. Төвийн нэрийг англиар “National Center for Mothers, Newborns and Women-II” гэж орчуулна.

1.7. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

1.8. Төвийн нэр, үйлчилгээний хамрах хүрээг илэрхийлсэн билэгдэл, туттай байна.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

2.1.1. Үйлчлүүлэгч төвтэй, хүнлэг, энэрэнгүй, ил тод, нээлттэй, тэгш, хуртээмжтэй үйлчилгээг үзүүлэх;

2.1.2. Төрийн хуулийг чандлан сахиж, тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг ханган, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөх;

2.2.3. Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг чандлах;

2.2.4. Хүний нөөцийг тасралтгүй сургах, хөгжүүлэх замаар эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх;

2.2.5. Тайлан, мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангаж, үйл ажиллагаандаа явцын, гүйцэтгэлийн хяналт, дүгнэлт хийж ажиллах;

2.2.6. Эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн нөөцийг оновчтой бүрдүүлэх, зүй зохистой ашиглах;

2.2.7. Жилийн үйл ажиллагааг өртөг зардлаар төсөвлөх, санхүүжилтийг урьдчилан төсөвлөгдсөн үйл ажиллагаанд зориулах, өр, авлагагүй ажиллах;

2.2.8. Олон улсын эмчилгээ, үйлчилгээний шилдэг хандлага, зарчмыг тасралтгүй нэвтрүүлж ажиллах.

2.2. Төвийн эрхэм зорилго: Эх, нярай, хүүхэд, эмэгтэйчүүдэд эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээг чанарын өндөр түвшинд, түргэн шуурхай, найдвартай үзүүлэхэд оршино.

2.3. Төвийн үнэт зүйлс

2.3.1. Мэргэшсэн, ёс зүйтэй, ур чадвартай, багаар ажиллах чадвартай, чадварлаг хүний нөөц;

2.3.2. Тэгш, хүртээмжтэй, чанартай, эрсдэлгүй эмнэлгийн тусlamж, үйлчилгээ;

2.3.3. Хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, техник, шинэ технологи, материаллаг нөөц;

2.3.4. Үйлчлүүлэгчийг энэ тэргүүнд тавих.

2.4. Төвийн стратегийн тэргүүлэх чиглэл:

2.4.1. Эрдэм шинжилгээ, сургалт, эмнэлгийн тусlamж үйлчилгээний гуравласан нэгдлийг бэхжүүлэх;

2.4.2. Анагаах ухааны нотолгоонд суурилсан ололтыг хэрэгжүүлэн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

2.4.3. Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн эмчилгээний болон мэс заслын оношилгоо, эмчилгээний олон улсын жишигт нийцсэн шилдэг арга технологийг нэвтрүүлэн, өргөжүүлэх;

2.4.4. Хүүхдийн хавдрын цогц тусlamж үйлчилгээг бүрдүүлэх;

2.4.5. Ураг, нярайн тандалт оношилгооны үндэсний хэмжээний төв болох;

2.4.6. Эмэгтэйчүүдийн тусlamж, үйлчилгээний загвар төв болох;

2.4.7. Цахим эмнэлгийг бий болгох.

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь дараах эрхтэй:

3.1.1. Төвийн эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн оролцоог дээшлүүлэх, хамтран ажиллах;

3.1.2. Эх барих, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхдийн анагаахын тулгамдсан асуудлаар нотолгоонд суурилсан үндэслэл бүхий санал, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллагуудад танилцуулж шийдвэрлүүлэх;

3.1.3. Оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ, судалгааны чиглэлээр ном товхимол, зөвлөмж, заавар хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох;

3.1.4. Эх барих, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхдийн анагаахын мэргэжилтэн бэлтгэх болон мэргэшүүлэх сургалт тогтмол зохион байгуулах;

3.1.5. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах;

3.1.6. Олон улсын байгууллага, гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцэж харилцан ойлголцлын санамж байгуулах, хэлэлцээ хийх;

3.1.7. Харилцан ойлголцлын санамж бичиг, хэлэлцээний хүрээнд мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, гадаадын мэргэжилтнээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх, олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочид, төлөөлөгч урих;

3.1.8. Чанартай тусламж, үйлчилгээг стандартын дагуу хүртээмжтэй үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын асуудлыг төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.9. Эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал, шийдвэр гаргах, мөрдүүлэх, албан хаагчдын цалин, нэмэгдэл, урамшууллын хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд тогтоох, хөдөлмөрийн сахилга, ажлын хариуцлага алдсан албан хаагчид холбогдох хууль дүрмийн дагуу хариуцлага тооцох;

3.1.10. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

3.2. Төв нь дараах үүрэгтэй:

3.2.1 Үндэсний хэмжээнд нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх барих, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхдийн анагаахын чиглэлээр лавлагaa тусламж, үйлчилгээ үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах;

3.2.2. Чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтын хүрээнд хэтийн болон дунд хугацааны төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжилтийг хангах;

3.2.3. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудад төрөлжсөн мэргэшлийн лавлагaa тусламж, дэмжлэг үзүүлэх;

3.2.4. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Эрүүл мэндийн сайдын тушаал, хөгжлийн хөтөлбөр, төсөл, стандарт, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, гүйцэтгэлийг хянах;

3.2.5. Эх, ураг-нярай, хүүхэд, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр өвчлөл, эндэгдлийн судалгаа, шинжилгээ хийж, эрүүл мэндийг сайжруулах, өвчлөл, эндэгдлийг бууруулах, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, нотолгоонд суурилсан бодлого, хөтөлбөр боловсруулах асуудлаар төрийн захиргааны төв болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, мэргэжил, арга зүйгээр хангах;

3.2.6. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт, ажлын байран дахь сургалтыг тасралтгүй зохион байгуулах, орон нутагт ажиллаж буй мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх;

3.2.7. Эх, нярай, хүүхэд, эмэгтэйчүүдийн өвчлөл, эндэгдлийн шалтгааныг тодорхойлох судалгаа хийж, зонхилон тохиолдох өвчлөл, эндэгдлийн тандалтын тогтолцоог бүрдүүлэх, өвчинөөс сэргийлэх, хянах ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах;

3.2.8. Эх, нярай, хүүхэд, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой үндэсний хөтөлбөр, стратеги хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах;

3.2.9. Эрдэм судалгааны ажлыг дэмжин анагаах ухааны ололт амжилт, оношилгоо-эмчилгээний дэвшилтэт арга, технологийг эмчилгээ, үйлчилгээнд нэвтрүүлэх, үр дүнг тооцож ажиллах;

3.2.10.Үйл ажиллагаандaa мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

3.2.11.Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;

3.2.12.Иргэд, үйлчлүүлэгч, албан хаагч, аж ахуйн нэгж, төр олон нийтийн байгууллагын санал, хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх;

3.2.13.Ажилтнуудын нийгмийн баталгаа, тогтвортой суурьшлыг хангах орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлыг боловсруулж, төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагуудад хургэх, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байраар хангах;

3.2.14.Ажилтнуудын мэргэжил, үр чадварт тохирсон цалин хөлс олгож, мэргэжил, мэдлэг, үр чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

3.2.15.Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит, нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн үр ашигтайг нь сонгон санхүүжүүлэх. \

Дөрөв. Төвийн бүтэц, зохион байгуулалт

4.1. Төвийн удирдах дээд албан тушаалтан нь Ерөнхий захирал байх бөгөөд Эрүүл мэндийн сайд томилж, чөлөөлнө.

4.2. Төвийн удирдлагын тогтолцоо нь Ерөнхий захирал, түүний дэргэдэх Захирлын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.

4.3. Төвийн Ерөнхий захирал нь дэд захирлууд, холбогдох алба, нэгжийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, хуулийн зөвлөх зэргийг оролцуулан Захирлын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно. Захирлын зөвлөл нь зөвхөн зөвлөх чиг үүрэгтэй байна. Эцсийн шийдвэрийг зөвхөн Ерөнхий захирал гаргана.

4.4. Төв нь эрдэм шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэллэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт гаргах, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх барих, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхдийн анагаахын чиглэлээр эрдэм судлалын ажлыг үндэсний хэмжээнд зохицуулах үүрэг бүхий Эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхий захирал батална.

4.5. Төвийн Ерөнхий захирал тушаал, Захирлын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.

4.6. Төв нь Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эмэн эмчилгээг зохицуулах хороо, Санал гомдлын хороо болон бусад шаардлагатай зөвлөл, хороод байгуулан ажиллуулна.

4.7. Ерөнхий захирлын эрх, үүрэг

4.7.1. Төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

4.7.2. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулах, биелэлтийг хангах, тайлагнах;

4.7.3. Төвийн бүтэц, алба, тасгийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлох, байгууллагын дотоод журам, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, ойрын болон хэтийн хөгжлийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

4.7.4. Дэд захирал, тасгийн эрхлэгч, албадын дарга, нэгжийн удирдлагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

4.7.5. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Төвийн орон тоо, ажилтнуудын цалин хөлсийг тогтоох,

4.7.6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, гэрээг цуцлах;

4.7.7. Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, олон улсын төсөл, хөтөлбөр, төрийн захирагааны төв байгууллагын гаргасан тушаал, дүрэм, журам, албан даалгаврын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих;

4.7.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авлигаас ангид ажиллах;

4.7.9. Төсвийг хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулах.

Тав. Төвийн санхүүжилт

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бурдэнэ.

5.1. Улсын төсөв,

5.2 Эрүүл мэндийн даатгал,

5.3 Үндсэн (хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусlamж, үйлчилгээний орлого) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, бусад хууль тогтоомжид нийцүүлэн олсон орлого гэх мэт),

5.4. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, байгууллага, хамт олны хандив, тусlamж,

5.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт,

5.6. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Зургаа. Төвийн хамтын ажиллагаа

6.1. Төвийг гадаад, дотоодод Ерөнхий захирал төлөөлнө.

6.2. Төвийн Ерөнхий захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

6.3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Ерөнхий захирал шийдвэрлэнэ.

6.4. Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга настай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

6.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Долоо. Төвийн үйл ажиллагаанд хориглох зүйл.

Төв нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.1. Улс төр, шашны зорилготой үйл ажиллагаа зохион байгуулах;

7.2. Хууль тогтоомжид зааснаас бусад хэлбэрээр орлого олох үйл ажиллагаа явуулах;

7.3. Хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

Найм. Төвийн дэд захирал, тасаг, нэгжийн чиг үүрэг

8.1. Эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал Монгол улсын шинжлэх ухаан технологийн хөгжлийн бодлого, дэлхийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн Төвийн эрдэм шинжилгээ, судалгааны бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх; төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах,

төлөвлөлт, хяналт-үнэлгээг нэгдсэн удирдлагаар хангах; Төвийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг мэргэжил, арга зүйгээр ханган хөгжүүлэх; эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт сурталчилгаа, цахим сүлжээ, мэдээллийн технологи, статистик мэдээллийн уялдааг ханган ажиллана.

8.2. Стратеги, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Төвийн стратеги төлөвлөлт, хөгжлийн чиг хандлагыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох; хяналт-шинжилгээ, үнэлгээг орчин үеийн эмнэлгийн удирдлагын зарчимд нийцүүлэн хийх; санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн албаны болон эмнэлгийн дэмжих үйлчилгээний тасгуудын үйл ажиллагааг эмнэлгийн тасаг, нэгжийн үйл ажиллагаатай уялдуулж нэгдсэн удирдлагаар ханган, тасралтгүй хөгжлийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

8.3. Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг болон Хүүхдийн эмнэлэг хариуцсан дэд захирлууд нь төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлогыг тодорхойлон, эмчилгээ, тусламж, үйлчилгээний төрөлжсөн мэргэшлийн тасаг, поликлиникийн үйл ажиллагааг бусад оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний алба, тасгуудын үйл ажиллагаатай уялдуулж нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хариуцсан эмнэлгийг бүрэн хэмжээгээр төлөөлж үйл ажиллагааны үр дүнг нь хариуцан ажиллана.

8.4. Тусламж үйлчилгээний зохицуулагч Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг болон Хүүхдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулагч нь төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний өдөр тутмын эмнэлэг үйлчилгээний асуудлыг зохицуулан, тушаал, шийдвэр, стандартын биелэлтийг газар дээр нь хангуулах, хэвшүүлэх, мэдээ, мэдээллээр хангах чиг үүрэгтэй ажиллана.

8.5. Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг нь нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх барих, эмэгтэйчүүд, ураг-нярайн чиглэлээр улсын хэмжээнд мэргэжил, арга зүйгээр ханган, лавлагаа тусламж үзүүлнэ. Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг нь нөхөн үржихүйн анагаах ухаан судлалын клиникууд бүхий нөхөн үржихүйн зөвлөх поликлиник, яаралтай тусламж, мэдээгүйжүүлэлт, хагалгаа, эрчимт эмчилгээ, амаржих, амаржсаны дараах тусламж үйлчилгээ үзүүлэх, эрсдэлтэй жирэмсэн судлал, дутуу тээлт судлал, эмэгтэйчүүдийн эмгэг судлал, сэргээн засах эмчилгээний тасагтай байна.

8.6. Хүүхдийн эмнэлэг Хүүхдийн анагаахын чиглэлээр улсын хэмжээнд мэргэжил, арга зүйгээр ханган, лавлагаа тусламж үзүүлнэ. Хүүхдийн эмнэлэг нь хүүхдийн зөвлөх поликлиник, эх хүүхдийн дотрын эмчилгээ, яаралтай тусламж, цусны эмгэг, хавдар, гемодиализ, сэргээн засах, нярайн тусламж, үйлчилгээ, ерөнхий болон төрөлжсөн мэс заслын тусламж, үйлчилгээний тасагтай байна.

8.7. Эрдэм шинжилгээний салбар Эх барих, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхэд судлал, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр эрдэм судлалын ажлыг удирдан зохион байгуулах, хэтийн төлөв, бодлого тодорхойлох; сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах; төгсөлтийн дараах мэргэжил олгох, мэргэшүүлэх болон ажлын байрны сургалт зохион байгуулах асуудлыг хариуцна. Төвийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт сурталчилгаа, цахим сүлжээ, мэдээллийн технологи, статистик мэдээллийн албуудаас бүрдэнэ.

8.8. Дэмжих үйлчилгээний албад

8.8.1. Хүний нөөц, хууль эрх зүйн алба Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл, хөшүүргийг бий болгох гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах, авлигаас ангид байлгах, шүүх хууль хяналтын байгууллагад Төвийг төлөөлөх, худалдан авалтыг зохион байгуулах зэрэг болно. Эх барих, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхдийн анагаахын чиглэлээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулна. Түүнчлэн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, төлөвлөгөө гарган хангарт, хуваарилалт, байршуулалт хийх, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, стандартын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, чадавхижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, багц цагийн баталгаажуулалт хийх, ажилтнуудын хувийн хэрэг, мэдээний санг хөтлөх, тогтмол баяжилт хийх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, албан хаагчидтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлж ажиллана. Ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

8.8.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын алба Чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, стандарт мөрдөлтийг сайжруулах, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх, хяналт тавих, халдварын хяналт сэргийлэлтийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.8.3. Эх барих, сувилахуйн алба. Эх барихуй болон сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах, эх барихуй болон сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, байгууллагын хэмжээнд эх барих, сувилахуйн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, хянах, заавар зөвлөгөө өгөх, сувилахуйн хяналтын хуудсыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх, эх барих болон сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварт хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг тасралтгүй сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулан арга, зүйгээр хангаж ажиллана.

8.8.4. Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн алба Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авна. Төвийн нягтлан бodoх бүртгэлийг санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцүүлж, харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангана. Санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.8.5. Хангамж үйлчилгээ, инженер технологийн алба Төвийн барилга, цахилгаан, ус, дулаан хангамж, эд хогшил, эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашин, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээтэй холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангана. Гадаад болон дотоод орчны тохижилтыг хийж, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангана.

8.8.6. Ариутгал халдвартгүйтгэлийн тасаг Төвийн хэмжээнд халдвартын хяналт, ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээг хийж, эмнэлгээс шалтгаалах халдвараас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авна.

8.8.7. Эм зүйн тасаг, Эм зүйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхтэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд тэсвэртэй нянгийн шалтгаант өвчин үүсэхээс сэргийлэх, шинэ эмийг эмчилгээнд нэвтрүүлэх, эмч мэргэжилтнүүдийг эмийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

8.8.8. Нэгдсэн лабораторийн тасаг Лабораторийн ерөнхий болон нарийвчилсан шинжилгээ хийж, эцсийн дүгнэлт гаргана. Лабораторийн чанарын хяналт, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

8.8.9. Эмчилгээний хоол судлалын тасаг Эх барих, эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн хоолыг эмчийн зааврын дагуу цэс боловсруулах, эмчилгээний хоол судлалын чиглэлээр мэргэжлийн сургалт, зөв хооллолтын сурталчилгаа зохион байгуулахаас гадна хүнсний аюулгүй байдлын хяналт тогтмол хийнэ.

8.8.10. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасаг Төвийн эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэгдэж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн найдвартай, бэлэн байдлыг хангах, засвар хийх, сэлбэгийг нөөцлөх, тогтмол хяналт хийж шинэчлэх асуудлыг зохицуулах, ашиглалтын паспортыг тогтмол шалгах, шинэ багаж тоног төхөөрөмж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан бурдуулж удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдийг шаардлагатай мэдээллээр хангана.


8.8.11. Инженер, техникийн тасаг Төвийн цахилгаан, дулааны хэвийн үйл ажиллагааг хангах, аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх, зохион байгуулах, сантехник, цахилгааны засвар үйлчилгээг тогтмол хийх үйл ажиллагааг хариуцна.

8.8.12. Төвийн аж ахуйн тасаг Төвийн дэд бүтэц, инженер, цахилгаан, дулааны шугам сүлжээг хариуцан Төвийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.

Ес. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах Төвийн Ерөнхий Захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

Эргүүл мэндийн сайдын 2020 оны 11 сарын
... едрийн тушаалтын хөрдүгээр хавсралт

“ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧУУДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ-II”-ийн БҮТЭЦ



Олон нийтийн зөвлөл: Эс зүйн салбар хороо, Анаагаахын ёс зүйн хангальтын хороо, Эмэн эмчилгээг зохицуулах хороо, Үйлдвэрний эвлэлийн хороо, Ахмадын хороо ба бусад

ТОВЧИЛСОН УГИЙН ТАЙЛБАР

АЭЭСТ- Амьсталын эрхтний эмгэг судлалын тасаг

ЦЭХСТ- Цусны эмгэг хавдар судлалын тасаг

ХБЭЭСТ- Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасаг

МЭСТ- Мэдрэлийн эмгэг судлалын тасаг

СЗЭТ- Сэргээн засах эмчилгээний тасаг

ЕМЗТ- Ерөнхий мэс заслын тасаг

ЭНМЗТ- Эрүү нүүрний мэс заслын тасаг

НМЗТ- Нудний мэс заслын тасаг

БМЗТ- Беөрний мэс заслын тасаг

ЧХХМЗТ- Чих хамар хоолойн мэс заслын тасаг

БДШЭСТ- Бөөр дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг

ЗСХЭЭСТ- Зүрх судас холбогч эдийн эмгэг судлалын тасаг

Нярайн ЭСТ- Нярайн эмгэг судлалын тасаг

Нярайн ЭЭТ- Нярайн эрчимт эмчилгээний тасаг

ЭЖСТ- Эрсдэлтэй жирэмсэн судлалын тасаг

ДТСТ- Дутту тээлт судлалын тасаг

СЗЭТ- Сэргээн засах эмчилгээний тасаг

ХЭ-ийн аж ахуйн хэсэг ЭБЭЭ-ийн аж ахуйн хэсэг- Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн аж ахуй

"Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II" эмнэлгийн орон тоо

| № | Мэргэжилтний нэр | Орон тоо |
|---|--|-----------------|
| Удирдлага, санхүүгийн ажилтны орон тоо | | |
| 1 | Ерөнхий захирал | 1 |
| 2 | Сургалт эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан дэд захирал | 1 |
| 3 | Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /Хүүхдийн эмнэлэг/ | 1 |
| 4 | Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг/ | 1 |
| 5 | Стратеги төлөвлөлт эрхэлсэн дэд захирал | 1 |
| 6 | Эрдэмтэн нарийн бичгийн дарга | 1 |
| 7 | Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан | 1 |
| 8 | Хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан | 1 |
| 9 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын албаны дарга | 1 |
| 10 | Чанарын менежер /Хүүхдийн эмнэлэг/ | 1 |
| 11 | Чанарын менежер /Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг эмнэлэг/ | 1 |
| 12 | Чанарын мэдээлэл хариуцсан эмнэлгийн мэргэжилтэн | 1 |
| 13 | Захирлын туслах | 1 |
| 14 | Хэвлэл мэдээллийн ажилтан | 1 |
| 15 | Нийгмийн ажилтан | 1 |
| 16 | Мэдээллийн технологийн ажилтан | 2 |
| 17 | Номын санч | 1 |
| 18 | Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга | 1 |
| 19 | Эрүүл мэндийн эдийн засагч | 1 |
| 20 | Нягтлан бодогч | 3 |
| 21 | Нярав | 3 |
| 22 | Эрүүл мэндийн даатгалын эмч | 3 |
| 23 | Эрүүл мэндийн даатгалын бага эмч | 1 |
| 24 | Хүний нөөц, хууль эрхзүйн албаны дарга | 1 |
| 25 | Хүний нөөцийн албаны менежер | 2 |
| 26 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, халдварт хамгаалал хариуцсан мэргэжилтэн | 1 |
| 27 | Тандалт судалгааны албаны дарга | 1 |
| 28 | Мэдээлэл зүй-Статистикч эмч | 1 |
| 29 | Мэдээлэл зүй-Статистикч бага эмч | 2 |
| 30 | Хуулийн мэргэжилтэн/зөвлөх | 1 |
| 31 | Бичиг хэрэг, архивын ажилтан | 1 |
| 32 | Захиргааны туслах ажилтан | 1 |
| 33 | Эм зүйч | 3 |
| 34 | Эмийн сангийн мэргэжилтнүүд | 6 |
| 35 | Лабораторийн эрхлэгч | 1 |
| 36 | Лабораторийн эмч | 4 |
| 37 | Лаборант | 15 |
| 38 | Шил угаагч | 2 |
| 39 | Үйлчлэгч | 2 |
| 40 | Сувилахуйн албаны дарга | 1 |
| 41 | Сувилахуйн арга зүйч | 2 |
| 42 | Ариутгалын тасгийн эрхлэгч /Халдварт судлаач/ | 1 |
| 43 | Тархвар судлаач | 2 |

| | | |
|----|---|------------|
| 44 | Ариутгагч | 5 |
| 45 | Анатомын эмгэг судлаач | 1 |
| 46 | Препараторчин | 1 |
| 47 | Эмгэг анатомын үйлчлэгч | 2 |
| 48 | Хангамж үйлчилгээ, инженер технологийн албаны дарга | 1 |
| 49 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер | 2 |
| 50 | Ерөнхий инженер | 1 |
| 51 | Тоног төхөөрөмжийн техникч | 2 |
| 52 | Цахилгааны инженер | 1 |
| 53 | Цахилгаанчин | 3 |
| 54 | Сантехникийн инженер | 1 |
| 55 | Сантехникч | 4 |
| 56 | Сантехникчийн слесарь | 9 |
| 57 | Лифтчин | 1 |
| 58 | Аж ахуйн дарга | 2 |
| 59 | Харуул | 6 |
| 60 | Хоол зүйн тасгийн эрхлэгч | 1 |
| 61 | Хоолны технологич | 1 |
| 62 | Ахлах тогооч | 1 |
| 63 | Тогооч | 8 |
| 64 | Туслах ажилтан | 4 |
| 65 | Үйлчлэгч | 6 |
| | Хэсгийн дүн | 143 |

Хүүхдийн эмнэлэг

| | | |
|----|----------------------------------|------------|
| 66 | Тасгийн эрхлэгч | 3 |
| 67 | Тусlamж үйлчилгээний зохицуулагч | 1 |
| 68 | Хүүхдийн эмч | 28 |
| 69 | Нярайн эмч | 12 |
| 70 | Хүүхдийн мэс заслын эмч | 10 |
| 71 | Эрчимт эмчилгээний эмч | 8 |
| 72 | Мэдээгүйжүүлгийн эмч | 8 |
| 73 | Ахлах сувилагч | 3 |
| 74 | Өдрийн сувилагч | 35 |
| 75 | Ээлжийн сувилагч | 70 |
| 76 | Мэс заслын сувилагч | 8 |
| 77 | Боолтын сувилагч | 4 |
| 78 | Үйлчлэгч | 26 |
| 79 | Цусны сувилагч | 1 |
| 80 | Трансфузиологич эмч | 1 |
| 81 | Техникч | 3 |
| | | 221 |

Хүүхдийн зөвлөх поликлиник

| | | |
|----|-------------------------------------|----|
| 82 | Төрөлжсөн мэргэшлийн кабинет | |
| 83 | Тасгийн эрхлэгч | 1 |
| 84 | Ахлах сувилагч | 1 |
| 85 | Шинжилгээний сувилагч | 1 |
| 86 | Цахим буртгэл, мэдээллийн ажилтан | 2 |
| 87 | Хөтөч | 2 |
| 88 | Хүүхдийн нарийн мэргэжлийн эмч | 25 |
| 89 | Оношлогооны хэсэг | |
| 90 | Их эмч | 10 |
| 91 | Сувилагч | 6 |

| | | |
|---|--|------------|
| 92 | Техникч | 3 |
| 93 | Үйлчлэгч | 8 |
| | Хэсгийн дүн | 59 |
| Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг | | |
| 94 | Тасгийн эрхлэгч | 8 |
| 95 | Тусlamж үйлчилгээний зохицуулагч | 1 |
| 96 | Эх барих эмэгтэйчүүдийн эмч | 34 |
| 97 | Эрчимт эмчилгээний эмч | 8 |
| 98 | Мэдээгүйжүүлгийн эмч | 8 |
| 99 | Нөхөн сэргээхийн эмч | 1 |
| 100 | Зөвлөх эмч | 1 |
| 101 | Зүрх судасны эмч | 1 |
| 102 | Ахлах сувилагч | 8 |
| 103 | Эх баригч | 81 |
| 104 | Өдрийн сувилагч | 25 |
| 105 | Ээлжийн сувилагч | 44 |
| 106 | Мэс заслын сувилагч | 8 |
| 107 | Боолтын сувилагч | 4 |
| 108 | Үйлчлэгч | 24 |
| Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник | | |
| 109 | Тасгийн эрхлэгч | 1 |
| 110 | Ахлах сувилагч | 1 |
| 111 | Цахим бүртгэл, мэдээллийн ажилтан | 2 |
| 112 | Хөтөч | 1 |
| 113 | Нарийн мэргэжлийн эмч | 9 |
| 114 | Их эмч | 8 |
| 115 | Сувилагч | 10 |
| 116 | Үйлчлэгч | 2 |
| | Хэсгийн дүн | 290 |
| Сургалт, сурталчилгааны алба | | |
| 117 | Албаны дарга | 1 |
| 118 | Дотоод сургалт хариуцсан мэргэжилтэн | 1 |
| 119 | Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн | 2 |
| 120 | Нийгмийн эрүүл мэндийн ажилтан | 2 |
| | Хэсгийн дүн | 6 |
| Соёл, үйлчилгээний алба | | |
| 121 | Албаны дарга | 1 |
| 122 | Менежер | 1 |
| | | 3 |
| 123 | Хөтөч ажилтан (хүүхдийн эмнэлэг, эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг) | |
| | Хэсгийн дүн | 5 |
| | НИЙТ | 724 |

"Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II" эмнэлгийн орон
тооны товчоо

| № | Мэргэжил | Хүний тоо |
|---|--------------------|-----------|
| 1 | Хүний их эмч | 153 |
| 2 | Сувилагч | 232 |
| 3 | Эх баригч | 81 |
| 4 | Лаборатори | 20 |
| 5 | Эм зүйч | 9 |
| 6 | Инженер | 5 |
| 7 | Үйлчлэгч | 70 |
| 8 | Захиргааны ажилтан | 60 |
| 9 | Бусад | 94 |
| | НИЙТ | 724 |